

МОНГОЛ ОРНЫ ГАРДАЛАВЧТАН (*CHIROPTERA: VESPERTILIONIDAE*)-Ы АНГИЛАЛ ЗҮЙН АСУУДАЛД

Ж.Ариунболд

МУБИС, БУС, Амьтан судлал, экологийн тэнхэм
j_ariunbold@yahoo.com

Түлхүүр үг: Гардалавчтан, Ангилал, Зүйл, Монгол улс.

Оршил:

Дэлхийд 1200 гаруй зүйл гардалавчтан (Chiroptera) хойд болон өмнөд туйл, зарим нэг арлуудаас бусад бүхий л нутгуудад тархжээ. Энэ нь дэлхийн нийт хөхтөн амьтдын 20 орчим хувь нь юм. Манай орны уур амьсгал эрс тэс хувьсамтгай учраас халуун дулаан оронтой харьцуулбал гардалавчтан зүйлийн тоо цөөн, жилийн тодорхой хугацаанд идэвхтэй байж хүйтэн сэрүүний үед ичээнд орох буюу нүүдэллэдэг. Сэрүүн уур амьсгалтай Монгол оронд тагийн бүслүүрээс бусад бүсэд тохиолдох гардалавчтанууд нь бүгд шавжаар хооллон, хөнөөлт шавжийн тоог зохицуулж, экосистемд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн олон улс орон нийт гардалавчтанаа улаан номд бүртгэх, амьдрах орчин үүрийг нь хамгаалах, үүр барьж өгөх зэргээр хамгаалдаг.

Монголын гардалавчтаны ангилалзүй бүрэн тодорхой болж, зүйлийн бүрдэл нь бүрэн гүйцэд илрээгүй байгаа бөгөөд сүүлийн үед Герман, Орос, АНУ, Англи, Канад зэрэг улс орны эрдэмтэд манай оронд ирж судлах, өөрийн орны цуглуулгад хадгалагдаж буй Монголын гардалавчтаны дээжийг ахин нягталж, ангилалзүйг өөрчлөн, шинэ зүйл нэмэх зэрэг өөрчлөлтүүдийг судалгааны шинэлэг аргуудад тулгуурлан хийх болжээ. Энэ өгүүлэлд Монгол орны гардалавчтаны талаар сүүлийн үед судлаачдын гаргасан судалгааны үр дүн, мэдээ баримтууд болон өөрийн судалгааны зарим үр дүнг тусгалаа. Мэдээ баримтыг нэгтгэхдээ тухайн зүйлийг Монголоос анх тэмдэглэсэн, нийт зүйлүүдийг нэгтгэн бичсэн, ангилалзүйг шинэчилсэн гол бүтээлүүдийг ашиглан одоогийн гардалавчтаны зүйлийн бүрдэлийг тогтоов. Тус орны гардалавчтаны судалгаанд холбогдох мэдээ баримтын талаар Allen, (1938); Банников, (1954); Дуламцэрэн, (1970); Соколов, (1980); Wilson and Reeder, (2005); Clark et al., (2006); Spitzenberger et al., (2006); Dolch et al., (2007); Лебедев и др., (2010); Datzmann et al., зэрэг судлаачдын бүтээлд тусгагдаж, мөн сүүлийн үед дэлхийн хэмжээний олон бүтээлд гардалавчтаны ангилалыг шинэчлэн бичжээ.

Монголын гардалавчтаны зүйлүүдийн олонхыг палеоарктикт өргөн тархацтай хэмээн үзэж байсан боловч сүүлийн үеийн ангилалын судалгаагаар эдгээр зүйлүүдийн Азийн хэсэгт тархсан зарим хэлбэрүүдийг нь тусгаар бие даасан зүйл болгон бичиж байна. Монголд тэмдэглэгдээгүй зүйлүүдийн тархац улсын хилийн ойр байгаа учраас цаашид шинэ зүйлийг ч шинээр тэмдэглэх боломжтой. Байгаль цаг уур эрчимтэй өөрчлөгдөж буй өнөө үед орчны өөрчлөлтөд мэдрэмтгий эдгээр амьтдын тоо толгой, бүлгэмдэл ч мөн өөрчлөгдөж байна. Иймд эдгээр өөрчлөлтийг тусган гардалавчтаны зүйлийн бүрдэл, ангилалын асуудлыг нягтлан боловсруулж нэгтгэх шаардлагатай.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй:

Гардалавчтаны ангилалзүй, нэршил, тархацын мэдээ баримтыг боловсруулахдаа Павлинов и др., (2002), Wilson and Reeder (2005), Matveev et al., (2005), Spitzenberger et al., (2006), Dolch et al., (2007), Кожурина (2009), <http://zmmu.msu.ru/bats> зэрэг бүтээл, эх

сурвалж болон өөрийн судалгааны материалаас ашиглав. Гардалавчтаны монгол нэрийг С.Дуламцэрэн (2003) болон оноосон монгол нэргүй зүйлүүдэд шинээр монгол нэршлийг өгөв.

Судалгааны үр дүн:

Монгол улс Сибирийн их хөвч тайга, Төв Азийн говь, цөл, хээр тал, Алтайн өндөр уулсын уулзварт оршдог өргөн уудам газар нутагтай билээ. Одоогоор Монгол оронд 1 багийн, 1 салбар баг, 1 овог, 3 дэд овог, 7 төрөл, 20 зүйлийн гардалавчтан тэмдэглэгдээд байна (Хүснэгт-1).

Монгол орны гардалавчтаны ангилал зүй, зүйлийн бүрдэл

Хүснэгт-1

| | | Латин нэр | Монгол нэр | |
|--|------------------------------|---|--|---------------------|
| Chiroptera Blumenbach, 1779 Гардалавчтан | Microchiroptera Dobson, 1875 | Vespertilionidae Gray, 1821 Багваахайнхан | Дэд овог <i>Murinininae</i> | |
| | | | <i>Murina</i> Gray, 1842 | ацмар* |
| | | | <i>Murina leucogaster</i> Milne-Edwards, 1872 | бишгүүр ацмар* |
| | | | Дэд овог <i>Myotinae</i> | |
| | | | <i>Myotis</i> Каур, 1829 | багваахай |
| | | | <i>Myotis petax</i> Hollister, 1912 | зүүний багваахай* |
| | | | <i>Myotis brandtii</i> (Eversmann, 1845) | ойсог багваахай |
| | | | <i>Myotis aurascens</i> Kuzyakin, 1935 | хээрийн багваахай* |
| | | | <i>Myotis nipalensis</i> (Dobson, 1871) | Балбын багваахай* |
| | | | <i>Myotis ikonnikovi</i> Ognev, 1912 | бяцхан багваахай* |
| | | | <i>Myotis frater</i> Gl. Allen, 1923 | уртсүүлт багваахай* |
| | | | <i>Myotis bombinus</i> Thomas, 1906 | амарын багваахай* |
| | | | <i>Myotis blythii</i> (Tomes, 1857) | шовхчихт багваахай* |
| | | | Дэд овог <i>Vespertilioninae</i> | |
| | | | Триба <i>Plecotini</i> | |
| | | | <i>Plecotus</i> Geoffroy, 1818 | соотгой |
| | | | <i>Plecotus kozlovi</i> Bobrynskoj, 1926 | саарал соотгой* |
| | | | <i>Plecotus ognevi</i> Kishida, 1927 | бор соотгой* |
| | | | <i>Plecotus strelkovi</i> Spitzenberger, 2006 | хиргис соотгой* |
| | | | <i>Plecotus turkmenicus</i> Strelkov, 1988 | чантуу соотгой* |
| | | | Триба <i>Pipistrellini</i> | |
| | | | <i>Nyctalus</i> Bowdich, 1825 | бүрэнхийч |
| | | | <i>Nyctalus noctula</i> (Schreber, 1774) | хонгор бүрэнхийч |
| | | | Триба <i>Vespertilionini</i> | |
| | | | <i>Vespertilio</i> Linnaeus, 1758 | сармаахай |
| | | | <i>Vespertilio sinensis</i> (Peters, 1880) | дорнын сармаахай |
| | | | <i>Vespertilio murinus</i> Linnaeus, 1758 | буурал сармаахай |
| | | | <i>Hypsugo</i> Kolenati, 1856 | турсаахай |
| | | | <i>Hypsugo alaschanicus</i> (Bobrynskoj, 1926) | Алашаа турсаахай* |
| | | | Триба <i>Eptesicini</i> | |
| <i>Eptesicus</i> Rafinesgue, 1820 | сарсаахай | | | |
| <i>Eptesicus nilssonii</i> (Keyserling et Blasius, 1839) | умрын сарсаахай | | | |
| <i>Eptesicus gobiensis</i> Bobrynskoj, 1926 | говьсог сарсаахай | | | |
| <i>Eptesicus turcomanus</i> (Eversmann, 1840) | хожуу сарсаахай | | | |

*- Албан бус монгол нэр

1. *Eptesicus gobiensis* Bobrynskoj, 1926 говьсог сарсаахай

Монголд *E.g.gobiensis* Bobrynskoj, 1926 зүйлхэн (Стрелков, 1986) бий. Манай орны говь, цөл, хээрийн бүсээр тархан амьдардаг.

2. *Eptesicus nilssonii* (Keyserling et Blasius, 1839) умрын сарсаахай

Энэ зүйл манай Хангай, Хэнтий, Хөвсгөл, Их хянган, Монгол алтайн нурууны умард хэсгээр тархсан тайга, ойт хээрийн бүсэд түгээмэл тархацтай. Умрын сарсаахайн *E.n.nilssonii* Keyserling et Blasius, 1839 номиналь хэлбэр манайд тархжээ (Банников, 1954).

3. *Eptesicus turcomanus* (Eversmann, 1840) хожуу сарсаахай

Eptesicus serotinus (Schreber, 1775)-с тусгаарлан бие даасан зүйл болгосон (Кожурина, 2009). Өмнөговийн Хөрх уул, Зулганайн баянбүрдэд тэмдэглэжээ (Банников, 1954; Dolch et al., 2007).

4. *Hypsugo alaschanicus* (Bobrynskoj, 1926) Алашаа турсаахай

Hypsugo savii (Bonaparte, 1837) борхон турсаахайгаас тусгаарлан бие даасан зүйл болгосон. Манай орны баруун болон өмнө зүгийн говь, цөлийн бүсэд баянбүрд, нуур, булаг шанд бүхий газруудаар тэмдэглэжээ.

5. *Murina leucogaster* Milne-Edwards, 1872 бишгүүр ацмар

Баруун умард Хэнтийд Ерөө голын савд тэмдэглэсэн (Clark et al., 2006). Энэ зүйлийг *Murina leucogaster* Milne-Edwards, 1872-с тусгаарлаж тусдаа бие даасан зүйл болгосон. Монголд ангилалын судалгаа одоогоор хийгдээгүй. *M.l.sibirica* Kastschenko, 1905 зүйлхэн байх боломжтой.

6. *Myotis aurascens* Kuzyakin, 1935 хээрийн багваахай

Сүүлийн үед Монгол оронд нэлээд өргөн тархалттай *Myotis mystacinus* (Kuhl, 1819) сахалт багваахайн ангилалзүйд нэлээд өөрчлөлт орсон байна. *M.m.mongolicus* (Kruskop, Borissenko, 1996) зүйлхэнийг *Myotis aurascens* Kuzyakin, 1935 хэмээх тусдаа бие даасан зүйл (Benda & Tsutsulina, 2000) болгож үзэх болсон иймд манайд *M.a.mongolicus* Kruskop, Borissenko, 1996 зүйлхэн тархжээ.

7. *Myotis blythii* (Tomes, 1857) шовхчихт багваахай

Бид энэ зүйлийг баруун Монголын Булган голын сав Улиастайн амнаас 2011 оны 7 сард Монголд анх удаа тэмдэглэсэн. Энэ дээжинд ангилалын судалгааг нарийвчлан хийж байна.

8. *Myotis bombinus* Thomas, 1906 амарын багваахай

Монголд анх удаа Хэнтийн нуруунд Балж голын эргээс бид 2008 оны 6 сард нэг бодгалийг барьсан (Ариунболд нар, 2008). Энэ зүйлийг *Myotis nattereri* (Kuhl, 1817)-с тусгаарлаж тусдаа бие даасан зүйл болгосон. Монголд *M.b.amurensis* Ognev, 1927 зүйлхэн тархаж байгаа (Кожурина, 2009) бололтой.

9. *Myotis brandtii* (Eversmann, 1845) ойсог багваахай

M.b.gracilis Ognev, 1927, *M.b.sibiricus* Kastschenko, 1905 зүйлхэнүүд Монголын Төв болон Умард нутгийн ой, ус бүхий газар, зүүн хязгаарт Хянганы салбар уулс, Монгол Дагуурын хээрд тархсан. *M.b.gracilis* зүйлхэнийг зарим судлаачид *Myotis gracilis* Ognevi, 1927 бие даасан зүйл болгосон (Horacek et al., 2000; Dolch et al., 2007), цаашид ангилалын судалгаа шаардлагатай.

10. *Myotis frater* G.I. Allen, 1923 уртсүүлт багваахай

ОХУ-н судлаачид Монголын хөхтний зүйлийн бүрдэлд шинээр нэмж (Лебедев и др., 2010) бичсэн байх боловч хаанаас, хэдийд, хэн барьж цуглуулсан талаар ямар нэгэн мэдээ, баримт байхгүй байна. Бидний судалгаагаар 2011 оны 6 сард Ерөө голын саваас

энэ зүйлийг барьсан бөгөөд энэ нь *M.f.eniseensis* Tsytsulina et Strelkov, 2001 зүйлхэн (Кожурина, 2009) байж болохоор байна.

11. *Myotis ikonnikovi* Ognev, 1912 бяцхан багваахай

Хангай, Хэнтийн нурууны ойг нутгуудад одоогоор цөөн газраас олдсон (Ариунболд нар, 2008). Монголд зүйлхэний судалгаа хийгдээгүй.

12. *Myotis nipalensis* (Dobson, 1871) Балбын багваахай

Сахалт багваахайн *M.mystacinus przewalskii*, зүйлхэнийг *Myotis nipalensis* Dobson, 1871 хэмээх бие даасан зүйл (Wilson et al., 2005) болгож үзсэн. Манай оронд *M.n.przewalskii* Bobrynskoу, 1926 зүйлхэн тархана.

13. *Myotis petax* Hollister, 1912 зүүний багваахай

Энэ зүйл багваахайг өмнө нь уссаг багваахай (*Myotis daubentonii* (Kuhl, 1817))-д хамааруулдаг байв. Монголд тархсан *Myotis daubentonii ussuriensis* Ognev, 1927 зүйлхэнд В.С.Матвеев, С.В.Крускоп, Д.А.Крамеров нар генетик, морфологийн судалгаа хийж 2005 онд тусдаа бие даасан зүйл *Myotis petax* Hollister, 1912 болохыг тогтоожээ. Монголд *M.p.petax* Hollister, 1912, *M.p.ussuriensis* Ognev, 1927 зүйлхэнүүд тархсан.

14. *Nyctalus noctula* (Schreber, 1774) хонгор бүрэнхийч

Ховд голын хөндийд Онгоцны улаан уулнаас олж тэмдэглэсэн (Самьяа нар, 1993). Одоогоор үүнээс өөр тархацын цэг манай оронд олдоогүй байна. Монголд *N.n.meklenburzevi* Kuzyakin, 1934 зүйлхэн байх боломжтой.

15. *Plecotus kozlovi* Bobrynskoу, 1926 саарал соотгой

Соотгойн ангилалзүй өөрчлөгдөж Монголд тархах *Plecotus austriacus* (Fischer, 1829) нь *Plecotus kozlovi* гэсэн зүйл болохыг тогтоожээ (Spitzenberger et al., 2006). Энэ зүйл манай орны өмнө болон зүүн өмнө зүгийн хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүсээр тархжээ.

16. *Plecotus ognevi* Kishida, 1927 бор соотгой

Монголын тайга, ойт хээр, хээрийн бүсэд тархсан *Plecotus auritus* (Linnaeus, 1758) нь *Plecotus ognevi* гэсэн зүйл болохыг сүүлийн үеийн ангилалын судалгааны дүнд тогтоожээ (Spitzenberger et al., 2006). Энэ зүйл Умард Монголын нутгаар тархсан байна.

17. *Plecotus strelkovi* Spitzenberger, 2006 хиргис соотгой

ГовьАлтай аймагт мөн Ховд аймгийн Булган голын орчмын цөл, цөлөрхөг хээрийн бүсэд тэмдэглэгдсэн (Spitzenberger et al., 2006; Dolch et al., 2007).

18. *Plecotus turkmenicus* Strelkov, 1988 чантуу соотгой

Өмнөговьд Зулганайн баянбүрдээс Монголд анх удаа нэг бодгалийг барьжээ (Dolch et al., 2007).

19. *Vespertilio murinus* Linnaeus, 1758 буурал сармаахай

Монголын тайга, ойт хээр, хээр, говийн бүсэд өргөн дэлгэр тархалттай (Stubbe 2007). Манайд *V.murinus murinus* Linnaeus, 1758 зүйлхэн тархана.

20. *Vespertilio sinensis* (Peters, 1880) дорнын сармаахай

Дорнын сармаахайн *V.s.anderssoni* Wallin, 1962 (Тиунов, 1997) зүйлхэн Монголд тархдаг. Монголд Хянганы нуруу, дагуурын хээр тал, говийн бүсэд тархсан. Дорнын сармаахай нь тал хээрийн бүсэд синантропны орчинг голдуу сонгож амьдардаг (Ариунболд, 2011).

Хэлэлцүүлэг:

Монгол орны зэрлэг хөхтний баг буюу бүлгүүд дотроос харьцангуй хамгийн хожуу, тухайлбал XIX зууны сүүлийн хагасаас (Радде, 1862) шинжлэх ухаанд анх бүртгэгдэж эхэлсэн нь амьтад бол гардалавчтан юм. Гардалавчтаны судалгаа нь энэ бүлэг амьтны тусгайлан сонирхож судалсан нарийн мэргэжлийн судлаачаар бус, биологичид бусад судалгааны далимд голдуу явуул замналын судалгаагаар тохиолдсоныг цуглуулсан

мэдээ, хэрэглэхүүнийг уламжлалт ангилал зүйн аргаар боловсруулан дүгнэсэн мэдээнүүд байсан бол 2000 оны үеэс гадаад, дотоодын эрдэмтэд уламжлалт ангилалын судалгааны зэрэгцээ орчин үеийн судалгааны аргуудыг хэрэглэх болсноор зүйлийн бүрдэл нэмэгдсэн байна (хүснэгт-2).

Гардалавчтаны зүйлийн бүрдэл өөрчлөгдсөн байдал

Хүснэгт-2

| Эх сурвалж | А.Г.Банников (1954) | М.Шгуббе, Н.Хотолхүү (1968) | С.Дуламцэрэн (1970) | В.Е.Соколов, В.Н.Орлов. (1980) | С.Дуламцэрэн нар (1989) | Ж.Ариунболд (2002) | Clark et al., (2006) | (Dolch et al., 2007) | Datzmann et al., | (2011) |
|------------|---------------------|-----------------------------|---------------------|--------------------------------|-------------------------|--------------------|----------------------|----------------------|------------------|--------|
| Төрөл | 5 | 5 | 6 | 5 | 5 | 6 | 7 | 5 | 6 | 7 |
| Зүйл | 8 | 11 | 15 | 10 | 12 | 12 | 14 | 13 | 16 | 20 |

Цаашид судалгааг улам нарийсган, ангилалын судалгааны шинэлэг аргуудыг ашигласанаар шинэ зүйл, зүйлхэн нэмэгдэх боломж бий. Хээрийн хайгуул судалгааг Монгол орны хилийн ойролцоох болон бусад бүс нутагт явуулснаар *M.dasycneme*, *Barbastella darjelingensis*, *Pipistrellus pipistrellus*, *Eptesicus bobrinskoi*, *E.bottae*, *Hypsugo savii*, *Rhinolophus ferrumequinum* зэрэг зүйлүүдийн тархцыг нь шинээр тэмдэглэх боломжтой. Монгол улсын хилийн ойр хөрш оронд тэмдэглэгдсэн олон зүйлүүд байгааг анхааран тэднийг олж илрүүлэх судалгааг тодорхой нутгуудад хийж явуулах нь зүйтэй.

Дээрх зүйлүүдийн 14-г Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны бүс нутгийн улаан дансны үнэлгээгээр үнэлэхэд анхааралд өртөхөөргүй (LC), мэдээлэл дутмаг (DD) гэж үнэлэгдсэн (Clark et al., 2006) бөгөөд зарим зүйлүүдэд үнэлгээ хийгдээгүй байгаа нь цаашид ангилал зүй болон тархац, биологи, экологи, хамгааллын судалгааг хийж мэдээлэл цуглуулах шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт, санал:

Монгол оронд 1 багийн, 1 салбар баг, 1 овог, 3 дэд овог, 7 төрөлд хамаарах 20 зүйлийн гардалавчтан тэмдэглэгдээд байна. Энэ нь Монголын нийт хөхтөн амьтдын 15 хувийг эзэлж байна.

Гардалавчтаныг судлах, хамгаалах ажлыг хийх, хээрийн судалгаагаар шинэ зүйлүүдийг илрүүлэх, ангилалын судалгааг улам нарийвчлан хийж ангилалын асуудал нь эргэлзээтэй, бүрэн шийдэгдээгүй зүйлүүдийн ангилалыг тодорхой болгох шаардлагатай.

Дэлхийн олон улс орнууд нийт гардалавчтануудаа улаан номондоо бүртгэсэн байдгийг анхаарч экосистемд чухал ач холбогдолтой эмзэг эдгээр амьтадыг Монгол улсын улаан номонд бүртгэх шаардлага байна.

Улаан дансны үнэлгээгээр мэдээлэл дутмаг (DD) гэж үнэлэгдсэн зүйлүүд болон зүйлийн бүрдэлд шинээр нэмэгдсэн гардалавчтануудыг цаашид анхааран судалж мэдээ, баримт цуглуулан үнэлгээг шинэчлэн хийх хэрэгтэй.

Мэдээллийн эх үүсвэр:

Ариунболд, Ж., (2002). Монгол орны сарьсан жигүүртний зүйлийн бүрэлдэхүүн, тархац, экологийн зарим асуудал. Магистрын дипломын ажил. УБ.

- Ариунболд, Ж., Н.Батсайхан, Д.Дольш, (2008). Онон голын сав газрын гар далавчтан (Chiroptera Blum., 1779)-ы бүлгэмдэл. // Онон голын сав газар дахь байгаль орчин, тогтвортой хөгжил. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд. УБ. 92 х., 48-53.
- Ариунболд, Ж., М.Мөнхбаатар, Н.Нандин-Эрдэнэ, Д.Мөнхнаст (2011). Монгол орны дорнын сармаахай (*Vespertilio sinensis* Peters, 1880)-н тархац, биологи, экологи, хамгааллын зарим асуудал. // МУБИС-ийн БУС-ийн э/ш-ний бичиг. № 3. УБ.
- Банников, А.Г., (1954). Млекопитающие Монгольской Народной Республики. Изд. Акад. Наук СССР. Труды Монгольской комиссии. Вып. 53. М. 669 стр.
- Батсайхан, Н., Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, (2004). Их говийн дархан газрын жижиг хөхтөн амьтад. // Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. Улаанбаатар. Хуудас 96-105.
- Benda, P. & Tsytsulina K. A., (2000). Taxonomic revision of *Myotis mystacinus* group (Mammalia: Chiroptera) in the western Palearctic. *Acta Societatis Zoologicae Bohemicae* 64: 331–398.
- Datzmann Thomas, Dolch Dietrich, Batsaikhan Nyamsuren, Kiefer Andreas, Helbig Maria, Zophel Ulrich, Stubbe Michael, Mayer Frieder., (Manuscript). Cryptic diversity in Mongolian vespertilionid bats (Vespertilionidae, Chiroptera, Mammalia) “Results of the Mongolian-German Biological Expeditions since 1962, No. 299” *Journal of biogeography*. (Монгол-Германы хамтарсан судалгааны хэвлэгдээгүй бүтээл)
- Dolch, D., N.Batsaikhan, K.Thiele, F.Burger, I.Sheffler, A.Kiefer, F.Mayer, R.Samjaa, A.Stubbe, M.Stubbe, I.Krall & D.Steinhauser, (2007). Contributions to the Chiroptera of Mongolia with first evidences on species communities and ecological niches. *Erforsch. biol. Res. Mongolei (Halle/Saale)* (10): 407-458
- Дуламцэрэн, С., (1970). Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг. 240 х. 42-47.
- Дуламцэрэн, С., (2003). Дэлэнтний ангилбар зүй, ангилбарын монгол нэр томъёо (латин - монгол - англи - орос). I Улсын нэр томъёоны комиссын мэдээ № 148. Улаанбаатар. 72 хууд.
- Horacek, I., V. Hanak, J. Gaisler, (2000). Bats of the Palearctic Region: a Taxonomic and biogeographic review. Publication of Chiropterological information Centre ISEZ PAN. Proceedings of the 8th EBRS. Vol. 1:11-157
- Clark, E. L., Мөнхбат, Ж., Дуламцэрэн, С., Baillie, J. E. M., Батсайхан, Н., Самъяа, Р., Stubbe, M. (эмхтгэгчид ба редакторууд). (2006). *Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс*. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 1. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот (Монгол хэлээр).
- Кожурина Е.И., (2009). Конспект фауны рукокрылых России: систематик и распространение. *Plecotus et al.* 11-12: 71-105
- Kruskop, S.V. and A.V.Borissenko (1996). A new subspecies of *Myotis mystacinus* (Vespertilionidae, Chiroptera) from East Asia *Acta Theriologica* 41 (3): 331-335,
- Matveev, V. A., S. V. Krusko and D. A. Kramerov (2005). Revalidation of *Myotis petax* Hollister, 1912 and its new status in connection with *M.daubentonii* (Kuhl, 1817) (Vespertilionidae, Chiroptera) *Acta Chiropterologica*, 7(1): 23–37.
- Friederike Spitzenberger, Petr. P.Strelkov, Hans Winklera and Elisabeth Haring (2006). A preliminary revision of the genus *Plecotus* (Chiroptera, Vespertilionidae) bases on genetic and morphological results. – *Zoologica Scripta*, 35, 187-230
- Лебедев, В.С., А.А.Банникова, А.В.Суров (2010). Фауна млекопитающих Монголии: новое за последние 30 лет. // Экологические последствия биосферных процессов в экотонной зоне Южной Сибири и Центральной Азии: Труды Международной

конференции. Том I. Устные доклады. Уланбатор (Монголия), 6-8 сентября 2010 г. – Улан-Батор: издательство Бэмби сан, 302 с.

Самьяа, Р., Н.Даваа, М.Штуббе, Д.Сумьяа, О.Мөнхтогтох (1993). Баруун монголын хөхтөн амьтдын зарим ховор олдвор. // Баруун Монгол түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл биологийн нөөц баялаг. ЭШ бага хурлын илтгэлийн хураангуй. Улаанбаатар. 104-105.

Стрелков, П.П., (1986). Гобийский кожанок (*Eptesicus gobiensis* Bobrinkoy1926) новый вид рукокрылых фауны палеарктики. Зоологический журнал т LXV, вып. 7, 1103-1108.

Тиунов М.П., (1997), Рукокрылые дальнего Востока России. Владивосток. Дальнаука.

Stubbe, M., N.Chotolchu, (1968). Zur Säugetierfauna der Mongolei.- Mitt. Zool. Museum Berlin, Bd. 44, H.1.

Stubbe, M., A.Stubbe, H.v.Wehrden, N.Batsajchan, R.Samjaa, (2007). Biodiversity in space and time- towards a grid mapping for Mongolia. Erforsch. biol. Res. Mongolei (Halle/Saale) (10): 391-405

Wilson, D. L. & D. M. Reeder (eds) (2005). Mammal Species of the World, 3rd ed. Johns Hopkins Press

<http://zmmu.msu.ru/bats/>

Resume

Taxonomic status of the Bats (Chiroptera: Vespertilionidae) in Mongolia

Ariunbold Jargalsaikhan

Department of Zoology and Ecology, School of Natural Science, MSUE.

Mongolia is located in the wide range landlocked plateau of the Siberian forest between Central Asian Gobi, desert, Steppe and Altai high mountains. In Mongolia has comprising altogether in 20 species bats in 7 genus of family *Vespertilionidae* Gray, 1821 and they are 15% of total mammals. Fewer than 10 species bats distribution marked in the near of the Mongolian border and most researchers are hopefully new species finding to next field survey. We need using detailed new methods enable to finding new species and subspecies in the Mongolia.

The 'IUCN Red List Categories and Criteria were applied to 13 species bats in their Least Concern (LC), Data Deficient (DD) and some species are no rated in Mongolia. Farther needs detailed survey of ecology, biology, taxonomy and distribution of Mongolian bats.